




Мессеж банк үйлчилгээний гарын авлага

Худалдаа Хөгжлийн Банк



Гүйлгээний талаарх мэдээлэл авах

Харилцагч гүйлгээний мэдээллийг **мессежээр болон и-мэйлээр** авах үйлчилгээнд бүртгүүлэхийн тулд банкны салбарт эсвэл зайнаас банканд хандах боломжтой.

Үйлчилгээнд зайнаас бүртгүүлэхийн тулд:

- Банканд бүртгэлтэй цахим шуудангийн хаягаас info@tdbm.mn хаягт хүсэлт ирүүлэх;
- Банканд бүртгэлтэй утасны дугаараас банкны **1900-1977** дугаар (гадаадаас **976-70161988**) луу залгаж хүсэлт ирүүлэх;
- Банканд бүртгэлтэй утасны дугаараас банкны **133-133** тусгай дугаарт мессежээр хүсэлт ирүүлэх;
- ТиДиБи онлайн үйлчилгээний онлайн захиалга хүсэлтээр хүсэлтийг ирүүлэх боломжтой.

Харилцагч гүйлгээний мэдээлэл авах дансаа сонгож, орлого зарлагын алиных нь ч мэдээллийг авах боломжтой бөгөөд гүйлгээ гарах бүрд банкнаас уг гүйлгээний талаарх мэдээллийг **мессежээр эсвэл и-мэйлээр** танд мэдээлнэ. Мөн гүйлгээний мэдээллийг авах лимитийн хэмжээг дараах байдлаар сонгох боломжтой. Үүнд:

-
- 5'000₮
 - 25'000₮
 - 50'000₮
 - 100'000₮
 - 200'000₮
-


буюу түүнтэй тэнцэх гадаад валютаас дээш дүнтэй орлого болон зарлагын гүйлгээний мэдээллийг авах



Дансны үлдэгдлийн талаарх мэдээллийг авах

Дансны үлдэгдлийн талаарх мэдээлэл авахын тулд гар утасны **message** цэсэд хандан, үйлчилгээнд бүртгүүлэхэд сонгосон өөрийн нууц дугаарыг бичиж, **133-133** тусгай дугаарт илгээнэ. Таны дансны үлдэгдлийн талаарх мэдээлэл хариу мессежээр очно.

Жишээ нь: Харилцагч анх үйлчилгээнд бүртгүүлэхдээ өөрийн дансыг төлөөлөх нууц дугаараа 414 гэж сонгосон гэж үзье. Тэгвэл 414 гэсэн энэхүү нууц дугаараа бичиж, **133-133** дугаарт мессеж илгээснээр тухайн дансны үлдэгдлийн талаарх мэдээлэл ирнэ.






Валютын ханшийн талаарх мэдээлэл авах

Худалдаа хөгжлийн банкны валютын ханшийн мэдээлэл авахын тулд гар утасны **message** цэсэд хандан, тухайн валютын товчилсон тэмдэглэгээг бичиж, **133-133** тусгай дугаарт илгээнэ. /USD, EUR, CNY, GBP гэх мэт/

ХХБ-ны бэлэн болон бэлэн бус ханшийн мэдээлэл таны утсанд хариу мессежээр очно.






АТМ-ын байршлын талаарх мэдээлэл авах

Худалдаа, хөгжлийн банкны АТМ-ын байршлын мэдээллийг авахын тулд гар утасныхаа **message** цэсэд хандан, АТМ гэж бичиж, нэг зай аваад байршлын мэдээлэл авах гэж буй дүүргийн товчилсон нэрийг оруулан **133-133** тусгай дугаарт илгээнэ.

Жишээ нь: Харилцагч Баянгол дүүрэгт байрлах АТМ-ын мэдээллийг авахыг хүсэж байгаа бол мессежээр АТМ BGD гэж бичиж, **133-133** дугаарт илгээхэд хариу мессежээр тус дүүрэгт байрлах, цагийн хуваарийн дагуу ажиллаж байгаа АТМ-ын нэрс очих болно.








ТиДиБи онлайн үйлчилгээг ашиглан Мессеж банк үйлчилгээнд бүртгүүлэх

1. Та Мессеж банк үйлчилгээнд бүртгүүлэхийн тулд ТиДиБи онлайн үйлчилгээний **Үйлчилгээ>> Мессеж банк үйлчилгээ** цэсээр нэвтэрч, дараах төрлийн мэдэгдлүүдээс сонголтоо хийх боломжтой. Үүнд:


- ✓ Орлогын мэдэгдэл (Бэлэн)
- ✓ Орлогын мэдэгдэл (Бэлэн бус)
- ✓ Зарлагын мэдэгдэл (Бэлэн)
- ✓ Зарлагын мэдэгдэл (Бэлэн бус)
- ✓ Битүүмжийн гүйлгээний мэдэгдэл
- ✓ Дансны үлдэгдэл шалгах




2. Мэдэгдлийн төрлийг сонгож оруулсны дараа **Шимтгэл суутгах данс**, **Мэдэгдэл илгээгдэх дүнгийн доод хэмжээ** болон **Үйлчилгээнд нэмэх данс**-ыг сонгоно.

Мэдэгдэл илгээгдэх дүнгийн доод хэмжээ:

- ✓ Гүйлгээний дүн 5000 MNT-аас дээш
- ✓ Гүйлгээний дүн 25000 MNT-аас дээш
- ✓ Гүйлгээний дүн 50000 MNT-аас дээш
- ✓ Гүйлгээний дүн 100000 MNT-аас дээш
- ✓ Гүйлгээний дүн 200000 MNT-аас дээш




3. Мэдэгдэл хүлээн авах дансыг сонгосны дараа данс тус бүрийн ард харгалзах **Данс төлөөлөх тоо** автоматаар гарч ирэх бөгөөд та дурын дугаараар солих боломжтой. Хэрвээ **Данс төлөөлөх тоо**-г солихыг хүсвэл [572](#) тэмдэглэгээ дээр дарж, 1-3 оронтой тоог оруулан, **Хадгалах** товчийг дарж, **Үргэлжлүүлнэ**.



4. Үүний дараа харилцагчийн ТиДиБи онлайн үйлчилгээнд бүртгэлтэй бүх утасны дугаар болон имэйл хаяг гарч ирэх бөгөөд та мэдэгдэл хүлээн авах нэг **Утасны дугаар** болон нэг **Имэйл хаяг**-ийг сонгоно.

Бүртгэлтэй утасны дугаар болон имэйл хаягаа шинэчлэхийг хүсвэл ТиДиБи онлайн үйлчилгээний **Хэрэглэгчийн булан>> Хувийн мэдээлэл** цэсээр нэвтэрнэ үү.



5. Утасны дугаар болон Имэйл хаягийг сонгож оруулсны дараа **Үйлчилгээний нөхцөл**-тэй сайтар танилцан, зөвшөөрч байгаа тохиолдолд **Зөвшөөрөх** товчийг дарна. Дараа нь **Үргэлжлүүлэх** товчийг дарснаар Мессеж банк үйлчилгээнд амжилттай бүртгэгдсэн талаар мэдэгдэл гарна.

